

МОНГОЛ УЛС БОЛОН ИХ ГҮРНҮҮДИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

Н.УЛААН-ОД*

Сүүлийн үед Монгол Улс болон дэлхийн их гүрнүүдийн хоорондох харилцаа улам бүр өргөжин тэлж байна. Энэ харилцаанд Хятад, Америк, Япон, Энэтхэг зэрэг улс чухал байр эзлэх бөгөөд Орос, Монголын уламжлалт харилцаа сэргэн бэхжиж, Хятад, Монголын эдийн засгийн харилцаа эрчимжиж байгаа нь олон нийтийн анхаарлыг татаж байна.

Монгол Улс болон их гүрнүүдийн харилцаанд мэдэгдэм өөрчлөлт орж байх шалтгаан нь гэвэл: Олон улсын өнөөгийн өөрчлөлт хувиралт, их гүрнүүдийн Ази, Номхон далайн бүс нутаг дахь аюулгүйн стратеги бодлогын сонирхол, Монгол Улсын нутаг дэвсгэрийн байршлын чухал чанар болон өөрийн орны өөрчлөлт шинэчлэлтийн шаардлагаас болж байна. Энэхүү байдал нь Зүүн Хойт Азийн бүс нутгийн аюулгүйн орчныг өөрчлөх буюу Хятадын аюулгүйн орчин тойрныг нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Монгол Улс нь Хятад, Орос улсын дунд байрлах маш чухал стратегийн байршилтай улс юм. Дэлхийн их гүрнүүд өөрийн ашиг сонирхлын үүднээс харилцан өрсөлдөж, Монгол Улстай харилцаагаа өргөтгөн гүнзгийрүүлж байгаа нь нууц биш юм. Монгол Улс ч эдгээр байдалд зохицуулж “Олон тулгуурт” гадаад бодлого хэрэгжүүлж байгаа нь цагаа олсон зөв алхам болжээ.

Нэг. Монгол Улс болон их гүрнүүдийн харилцааны өнөөгийн байдал

1990 оноос өмнө Монгол Улс нь зөвхөн ЗХУ-ыг түшиглэсэн гадаад бодлогоо хэрэгжүүлж, бусад их гүрнүүдтэй харилцахдаа мөн энэхүү чиглэлийг баримталсаар ирсэн юм. “Хүйтэн дайн”-ы дараа Монгол Улс нь орчин үеийн байдалд зохицсон бодлого барьж, их гүрнүүдтэй харилцах харилцаагаа

өргөтгөн тэлж, маш эрчимтэй үйл ажиллагаа явуулсаар байна.

1. Сүүлийн үед АНУ болон Монголын харилцаа тасралтгүй хөгжих хандлагатай байна. “Хүйтэн дайн”-ы үед хоёр талын харилцаа нь харилцан ойлголцож, бие биеэ ойлгохыг хүссэн харьцангуй зогсонги байдалтай байснаа 1987 онд албан ёсны дипломат харилцаа тогтоосон юм. Америк, Монголын харилцаа нь “9.11”-ээр зааглагдаж хоёр шаттай хөгжиж ирсэн юм.

Нэгдүгээр шат нь: ХХ зууны 90-д оны үеэс АНУ нь ЗХУ задарсан орон зайг бөглөж, дээд зандааны зочид төлөөлөгчид томилон Монголд айлчлуулан, тус оронд тусламж үзүүлэх чухал нэг орон болон хувирчээ. Энэ хугацаанд хоёр тал “Засгийн газар хоорондын худалдааны гэрээ”, “Консулын гэрээ” болон “Америк Монголыг туслаж энхийг сахиулах арми томилох гэрээ”-г байгуулжээ. Үүнээс гадна АНУ, Монгол улсад улс төрийн олон ургальч үзлийг буй болгож, барууны орны баримжаанд нийцсэн ардчилсан тогтолцоог буй болгох санаа агуулагдаж байхыг үгүйсгэх аргагүй юм. 1991 онд АНУ “Монгол Улсын асуудлын тухай шийдвэр”-ийг баталж, тус улсад буй болсон олон намын тогтолцоог дэмжих, эдийн засаг техникийн тусламж үзүүлэх, хамгийн хөнгөлөлттэй нөхцлөөр хангах орон болгосон ба Япон, Солонгос, Дэлхийн банк, Олон Улсын Хөгжлийн Банктай хамтран Монгол Улсыг дэмжихээр тохиролцсон юм. Монгол Улс нь энэхүү байдлыг ухаалгаар ашиглаж, нэн олон талын дэмжлэг тусламж олох нөхцөл бололцоог хайж ирсэн байна.

Хоёрдугаар шат: “9.11”-ын дараа, АНУ нь Монгол Улстай улс төр, хүчний байгууллагуудын талаар хамтын ажиллагаагаа улам эрчимжүүлж ирсэн байна. Үүнд нэг

* Н.Улаан-Од - Өвөр Монголын Их Сургуулийн судлаач, докторант

талаараа Америкаас Монголд айлчлах төлөөлөгчдийн зиндааг үргэлжлүүлэн өндөржүүлжээ. 2004-2005 онд Америкийн төрийн өндөрлөгүүдээс эхлэн Ерөнхийлөгч нь хүртэл айлчилж, “Монголд нааштай хандах” хэмжээг оргилд нь хүргэсэн юм. Нөгөө талаар, Америк, Монголын цэргийн салбар дахь хамтын ажиллагаа нь улам гүнзгийрэн эрчимжиж байхаар барахгүй, Монгол улс нь одоо нэгэнт АНУ-ын Ази, Номхон далайн чухал бааз болж байгаа бодит илэрлүүд гарч эхэлсэн байна. Тухайлбал 2005 онд ерөнхийлөгч Ж.Буш Монголд айлчлах үедээ 11 сая ам.долларын цэргийн тусламж өгч, тус улсын цэрэг армийн байлдааны хүчин чадлыг дээшлүүлсэн байна. (1)

2. Монгол, Японы харилцаа нь Америк, Монголын харилцааны түлхэц хүчний нөлөөгөөр, хөгжлийн эрч нь маш түргэн дээшилсэн юм. Эдийн засгийн талаар Япон улс нь Монголд бусдаас илүү тусламж үзүүлж байгаа орны нэг болжээ. 1991-2004 оны хооронд Япон болон Дэлхийн Банк толгойлон Монгол улсыг дэмжих хандивлагчдын чуулганыг 10 удаа хуралдуулж, Монгол Улсад 3.6 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламж олгохоор амалсны дотор, 1450 сая ам.долларыг (2) Япон улсаас олгосноор хандивлагч гол улсын нэг болжээ. Одоо Япон улс нь Монголд хөрөнгө оруулагч улсуудын дотроос 5-р байрыг эзэлж байна. Улс төрийн талаар Япон, Монгол нь харилцан ойртож, ашигтай талаа нөхвөрлөж байна. Монгол улс нь эдийн засгийн тусламж олохыг түлхүү анхаарч, Япон улс нь тус орны стратегийн байршил болон зах зээлийн талаар илүү тооцоолж байна.

Цэргийн явдлын тал дээр ч Япон, Монголын аюулгүйн хамтын ажиллагаа нэлээд эрчимжиж байна. 2006 оны 8-р сард Монголын нутаг дэвсгэр дээр Японы өөрийгөө хамгаалах цэрэг “Хааны эрэлд-2006” 18 улс оролцсон хамтарсан цэргийн сургуульд оролцсон юм. Уг үйл ажиллагааг Монгол, Америкийн тал хамтран зохион байгуулсан бөгөөд Хятад, Орос хоёр улсыг ажиглагчаар оролцохыг урьсан юм. (3) Энэ нь Японы өөрийгөө хамгаалах цэргийнхэн анх удаа Монголын нутаг дэвсгэр дээр хөл тавьж байгаа явдал болно.

3. Монгол, Оросын уламжлалт харилцаа

сэргэн хөгжиж, харилцан ашигтай өнгө аясаар онцлог байна. ЗХУ задарсны дараа Монгол, Оросын харилцаа, улс төр, эдийн засгийн талаар нэг үе зогсонгуй байдалд орсон боловч, сүүлийн жилүүдэд хоёр талын уламжлалт түншийн харилцаа мэдэгдэхүйц хөгжиж, улс төрийн талаар хоёр улсын дээд зиндааны айлчлал өсөх хандлагатай болж байна.

2000 онд ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин Монголд айлчилж, хоёр улсын харилцан ашигтай хамтын ажиллагааны улс төрийн суурийг тавьж, 2006 оны 7-р сард Оросын ерөнхий сайд Монголд айлчилж, хамтын ажиллагааны агуулгаа нэн баяжуулав. 2005-2006 оны хооронд Монгол улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, ерөнхий сайд нар тус тус Орост айлчилснаар барахгүй, 2004 онд хоёр улс нь Орос, Монголын хоорондох их өрийн асуудлыг нааштай шийдвэрлэсэн байна.

Монгол, Оросын цэргийн явдлын аюулгүйн хамтын ажиллагаа нь мөн сэргэсэн юм. 2005 онд Монгол, Орос нь аюулгүйн хамтын ажиллагааны чуулга уулзалт хийж, Орос нь Монголд цэргийн зэр зэвсэг болон тоног төхөөрмж нийлүүлэхээр хэлэлцэж, хоёр улс нь хамтран терроризмын эсрэг хамтарсан цэргийн сургууль хийв.

4. 1985 оноос эхлэн Хятад Монголын найрсаг харилцаа сэргэж, эдийн засгийн хамтын ажиллагаа тасралтгүй эрчимжиж, хоёр улсын тэргүүн харилцан айлчилсан байна. 1994 онд шинэчлэн байгуулсан “Хятад, Монголын найрсаг харилцаа хамтын ажиллагааны тухай гэрээ”, 1998 онд байгуулсан “Хятад, Монголын хамтарсан тунхаг”-уудаас харахад Хятад Монголын харилцаа нь алхам алхмаар шинэ шатанд гарсан юм. Шинэ зуунд орсны дараа, Хятад, Монголын харилцаа улам гүнзгийрэн хөгжив.

Нэг талаар хоёр орны улс төрийн харилцаа тогтворжиж, харилцан итгэх итгэлцлийн хэмжээ мэдэгдэм дээшилсэн байна. 2003 оны 6-р сард Ху Жиньтао дарга Монголд айлчилж, Хятад Монгол хоёр улс нь “Сайн хөршийн харилцан итгэлцсэн түншийн харилцаа”-г хөгжүүлэхээр тохиролцов. 2005 онд Монгол улсын ерөнхийлөгч Н.Энхбаяр, Хятадад амжилттай айлчлав.

Нөгөө талаар, хоёр улсын эдийн засгийн харилцаа тасралтгүй дээшилсэн байна. 1998 оноос хойш Монголд хөрөнгө оруулагч улсуудын дотор Хятад улс тэргүүн байрыг жил дараалан эзэлсээр иржээ. Тухайлбал 2005 оны эцэс гэхэд, Монгол улсад бүртгүүлсэн Хятадын аж ахуйн нэгж 2000 гаруй байж, данслуулсан мөнгөний хэмжээ нь 460 сая ам.долларт хүрч, Монголын гадаадын хөрөнгө оруулалтын нийт хэмжээний 40 гаруй хувийг эзэлсэн байна.(4)

5. 2004 он хүртэл Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 14 хувь нь Олон улсын тусламжаас бүрдэж, үүний дотор нэлээд хэсэг нь хөнгөлөлттэй зээл буюу буцалтгүй тусламж болно. 2005 оны 7-р сард Европын Холбоо, Монголоос импортлох 7200 нэр төрлийн бараанд татвар тавихгүй гэж зарласан буюу 13 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлэхээр болсон юм. Монгол улс ба бусад их гүрнүүдийн хоорондох эдийн засгийн хамтын ажиллагаа дээшилсээр байна. Жишээлбэл Өмнөд Солонгос нь Монголд хөрөнгө оруулагч том улсын нэг болсон бөгөөд Монголын 10 мянга гаруй иргэдийг ажлын байраар хангаж байна.

Аюулгүйн хамтын ажиллагааны талаар, Монгол улс нь энхийг сахиулах цэргийн сургуульд Англи, Франц, Германтай хамтран ажиллаж байна. 2004 оны 6-р сард Английн талаас 80 мянган паунд гаргаж Монголд “НҮБ-ын байнгын тавын Монгол дахь энхийг сахих сургалт семинар”-ыг зохион байгуулж, Монгол дахь өөрийн орон зайгаа өргөтгөсөн байна. Франц нь 2003 онд Монголд Элчин сайдын яамаа дахин байгуулж, дараа жил нь түүндээ цэргийн атташегийн хэлтэс нээжээ.

Үүнээс гадна Монгол нь Энэтхэгтэй бүх талаар аюулгүйн хамтын ажиллагааг өрнүүлж, 2001 онд Монгол, Энэтхэг нь “Үндэсний батлан хамгаалалтын хамтын ажиллагааны гэрээ”-нд гарын үсэг зурж, 2003 оны 11-р сард Монгол, Энэтхэгийн Батлан хамгаалах яамны сайд нар уулзаж, Энэтхэгийн талаас Монголд цэрэг зэвсгийн тоног төхөөрөмж сэлбэн засах тусгай мэргэжилтэн томилох хэлэлцээр хийжээ. 2004 онд Монгол, Энэтхэг хоёр тал нь хойшид хамтарсан хээрийн сургууль хийхээр тохирчээ.

Хоёр. Монгол улс нь их гүрнүүдтэй харилцаагаа сайжруулахын учир шалтгаан

“Хүйтэн дайн”-ы дараа, Монгол улс ба их гүрнүүдийн харилцаанд маш олон хувиралт гарсан байна. Юуны өмнө, ЗХУ задарсан ба “9.11”-ны хэрэг явдал нь Монгол улс ба их гүрнүүдийн харилцааг бүх талаар хөгжүүлэхэд түлхэх хүч болж, маш чухал үүрэг гүйцэтгэсэн юм. 1992 оны 12-р сард Зөвлөлтийн цэрэг Монголоос бүрмөсөн гарч, үүгээр зааглан Монгол, Зөвлөлтийн 70 жилийн харилцаа хөндийрч, Монгол улс нэг үе улс төр, эдийн засаг, цэргийн явдлын түшиг тулгуураа алджээ.

Энэ үед АНУ нь аюулгүйн баталгаа ба ардчиллыг бий болгох, эдийн засгийг нь туслан дэмжихээр шалтаг болгож, Монголд нэвтрэн орж ЗХУ-ын орон зайг эзэлж амжсан юм. Үүний зэрэгцээ бусад их гүрнүүд ч бас Монголтой харилцаагаа сайжруулж, хамтын ажиллагаагаа хөгжүүлж эхэлсэн байна. Монгол улс өөрийн ашиг сонирхолынхоо дагуу, шинэ тусламж дэмжлэгээ олохын тулд эдгээр их гүрнүүдтэй харилцаагаа сайжруулж ажиллахаас өөр арга зам байхгүй болсон юм.

“9.11”-ийн дараа терроризмын эсрэг дайн зарласан нь, Монголд их гүрнүүдтэй хамтран ажиллах шинэ нөхцөл бололцоог бий болгож өгсөн байна. Үүний улмаар Монгол улс энхийг сахиулах цэргийн анги томилж, Афганистан болон Иракийн дайнд оролцох завшааныг олсноор барахгүй дэлхийн бусад их гүрнүүдтэй олон салбарт хамтран ажиллах өргөн боломжийг нээсэн юм.

АНУ ба бусад их гүрнүүдэд Ази дахь ашиг сонирхлоо хамгаалахад Монгол улс нь чухал үйлдэл үзүүлэх түнш гэж харагдаж байна. Хэдийгээр Америк, Монгол улсад цэргийн бааз байгуулах нь бодитой нийцэхгүй ч гэсэн, энэхүү салбарт хоёр талын хамтын ажиллагаа үргэлжлэн эрчимжих хандлагатай болсныг анхаарлын төвдээ байлгах хэрэгтэй болсон юм.

Сүүлийн хэдэн жилд Англи, Франц, Орос, Япон, Энэтхэг зэрэг их гүрнүүд Монголтой аюулгүйн талаархи хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх явдал нэн тодорхой болж байна. Зарим гүрнүүд Хятадын хүчирхэгжлийг санаатайгаар мушгин тайлбарлаж байх нь

түүнд зохих хэмжээгээр түлхэц хүч болсон юм. Тэд нар Монголоор Хятадыг хориглох “Шатар” болгож, өөрийнхөө Ази Номхон далай дахь ашиг сонирхлоо хамгаалах зорилгодоо хүрэхийг оролдож байна.

Монгол улс нь Хятад, Оростой тэнцвэртэй харилцах, “Гурав дахь хөрш”-тэйгээ адил тэгш харилцах, тэдний хүч нөлөөнд түшиглэж, өөрийн аюулгүй байдлаа хангахыг зорьж байна. Эдийн засгийн талаараа Монгол улс Хятад, Оростой харилцан ашигтай баталгаат худалдааны харилцаа байгуулахыг тэргүүн зорилтоо болгож, Америк, Япон, Герман зэрэг барууны их гүрнүүд ба Ази Номхон далайн улсуудтай гадаад худалдаагаа хөгжүүлж, зөвхөн дан ганц Орос, Хятадыг түшихэд үүсэж мэдэх аюулаас сэргийлж байх нь олзорхууштай хэрэг юм.

Цэргийн явдлын талаар Монгол улс Хятад, Оростой бас тэнцвэртэй хэвийн харилцааг хөгжүүлэхийг хичээж, бүс нутгийн хоорондох аюулгүйн байдалд зохицуулан, “Гурав дахь хөрш”-тэйгээ цэрэг армийн талаархи харилцаагаа хөгжүүлэх санаатай. Хөрш улсууд, гурав дахь хөрш, НҮБ болон бусад Олон улсын хамтарсан цэргийн хүчинтэй хамтран ажиллаж, шаардлагатай үедээ өөрийгөө хамгаалахыг эрмэлзэж байна.

Гурав. Монгол улс ба их гүрнүүдийн харилцааны хөгжлийн хандлага ба нөлөө

Сүүлийн жилүүдэд Монгол улс ба их гүрнүүдийн хоорондох ашиг сонирхол нь нэмэгдэж, олон талт хамтын ажиллагаа улам бүр гүнзгийрч, цар хүрээ нь тэлсээр байна. Монгол, Хятад, Орос гурван улс нь түүхийн ба газрын байршлын бодит байдлаасаа болж, харилцан түшилцэн орших харилцаа нь улам гүнзгийрэх болно. Монгол улс нь Орос, Хятадын аль нэгний дагуул орон болохыг хүсэхгүй нь мэдээж, гэвч Хятад, Оросын харилцаа муудах нөлөөг тэд тэсвэрлэхүйе бэрх юм.

Монгол ба их гүрнүүдийн харилцаа сайжрах болсон нь Ази, Номхон далайн болон онцгойлон Зүүн Хойт Азийн аюулгүйн тогтолцоог шинээр буй болгох хурдцыг

түргэтгэх үйлдэл үзүүлсэн юм. Үүнд Америк, Японы талаас Хятад, Оросыг хязгаарлах үйлдлийг нь түлхүү чухалчлан үзэж, Хятад, Орос нь хөрш орны аюулгүйн орчныг тогтвортой байлгах үйлдлийг нь онцлон үзэж байх нь нууц биш. Иймээс Монгол улс нь их гүрнүүдийн ашиг сонирхлыг тэнцвэртэй эв зүйтэй зохицуулах явдал нь түүний үндэсний эрх ашигт нь холбогдох маш чухал асуудал болно.

Улс төрийн талаас нь авч үзвэл, Монгол болон Хятад, Оросын эрх тэгш харилцан ашигтай байх нь, Монголын өөрөө эзэн мэдэж тусгаар тогтнолоо баталгаажуулахад ашигтай мөртөө Хятад, Оросын энх тайван найрамдлын орчинд улсаа хөгжүүлэх үйлсэд ч ашигтай юм. Монгол улсын тусгаар тогтнолын шинж чанар нь жинхэнэ утгаараа эрчимжих явдал нь, Монгол, Хятад, Оросын хэвийн хөрш орны харилцааны хөгжилд ашигтайгаар барахгүй дэлхийн энх тайван, тогтуун байдлыг хангахад ч маш чухал ач холбогдолтой юм.

Эдийн засгийн талаас нь авч үзсэн ч, Монгол нь Хятад, Орос, Европын Холбоотой харилцан түших гинж болон хэлбэржиж, Европын Холбоо нь Монголыг дэмжих гол зохион байгуулалт болж, Монгол нь Орост байгалийн баялаг хангах гол орон болж, Хятадын хил худалдааны том зах зээл болж, Хятадын эдийн засгийн өсөлт ба дэлхийн дэмжлэгт түшиглэж, эдийн засгаа хөгжүүлэх таатай боломжууд гарч ирж байгаа юм.

Онцлон тэмдэглэх нь: Монгол ба их гүрнүүдийн харилцааны хөгжилт нь аяндаа зохих хэмжээний сөрөг нөлөө авчиргахыг ч бас анхааран мэдэх хэрэгтэй. Ялангуяа Хятадад нэлээд яршиг төвөг ба дарамт шахалтыг бий болгож мэднэ. Үүнд:

1 \. Америк, Монголын харилцааны хөгжлийн хурдац нь Хятадын аюулгүйн орчинд сөрөг нөлөө үзүүлэх тал бий. Монгол нь “Гурав дахь хөрш”-ийн стратеги бодлогынхоо дагуу, Америкийн нөлөө илүү орж ирэхийг хүсэж байгаа явдал нь, Хятадад далд сүрдүүлэл болох магад. Америк нь Ази дахь эрх ашгаа бодолцон, Монголыг Орос, Хятадын дундах “Даралт намдуулах бүс” болгож, цаашилбал цэргийн бааз болгох далд санаа агуулж байхыг үгүйсгэхийн аргагүй юм.

2\ . Монголын “Гурав дахь хөрш”-ийн бодлого нь “Хятадын аюулын онол”-д орон зай гаргаж өгчээ. Их гүрнүүд Монголыг дэмжин туслаж хөрөнгө оруулах нь бодитой дээрээ тус орны эдийн засаг, нийгмийн хөгжилд ашигтай гэдэг боловч, цэргийн явдлын талаар нэвтрэн орох нь, Хятадын хойт хэсгийн аюулгүйн орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

3\ . Сүүлийн жилүүдэд их гүрнүүд Монголд хөрөнгө оруулах хэмжээгээ тасралтгүй нэмэгдүүлж байгаа явдал нь, Хятад, Монголын хоорондох эдийн засаг, худалдааны хэвийн байдлыг өөрчилж, манай улс Монголын зах зээлийг дангаар эзлэхээс болгомжилж байгаа бас нэг арга хэмжээ гэж үзэж болно.

4\ . Одоо Хятад, Монголын эдийн засгийн харилцаа ба нийгмийн итгэлцлийн хэмжээнд яаралттай шийдвэрлэх өдий төдий асуудал оршиж байна. Монгол хүний нүдэнд хамгийн сайн хамтын ажиллагааны түнш нь эхлээд Орос, дараа нь Америк, Японы дараа дөрөвдүгээр байрыг Хятад эзэлж байгаа нь, хүмүүсийн гайхашралыг төрүүлж байна.

5\ . Хятад, Монголын хамтын ажиллагааны харилцааг бүх талаар улам хөгжүүлж гэвэл хоёр тал хамтаар чармайж, идэвхтэй арга хэмжээ авч, тулгарч байгаа бэрхшээлийг эв зохистой шийдвэрлэх шаардлага гарч байгаа явдлыг, бүх нийтээрээ анхааралдаа авах цаг нэгэнтээ болжээ.

Зүүлт:

1. Хүэ Вэнь: “11 сая ам.долларын цэргийн явдлын тусламжаа өгч, нэг талаар цай ууж, нөгөө талаараа концерт үзнэ”, “Гариг цагийн сонин”, 2005.11.23 3-р хуудас
2. Жан хай бинь: “Япон улс Монголын дөрөв дэх хөрш болох гэж байна”, “Олон улсын тэргүүн эгнээн дэх индэр сонин”, 2006. 3. 31, 4-р хуудас
3. “Олон улсын тэргүүн эгнээн дэх индэр сонин”, 200..3.31, 4-р хуудас
4. Ян Тао: “Америк Монголд Солонгос хүнийг хүлээн авах даралт үзүүлж байна”, “Гариг цагийн сонин”, 2004.11.24, 64-р хуудас

2007 оны 1-р сар